



МОНГОЛ УЛСЫН
ДЭЭД ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 07 сарын 16 өдөр

Дугаар А/47

Улаанбаатар хот

Хөрөнгө зарцуулах тухай

Шүүхийн захиргааны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 170 дугаар зарлигийг тус тус үндэслэн Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн ТУШААХ нь:

1. Тулгар төр байгуулагдсаны 2226 жил, Их Монгол Улс байгуулагдсаны 810 жил, Ардын хувьсгалын 96 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Улсын Дээд шүүхийн шүүгч Л.Атарцэцэг “Гавъяат хуульч” цол, тэмдэг-ээр, шүүгч Ч.Хосбаяр “Хөдөлмөрийн гавъяаны Улаан туг” одонгоор, Захиргааны хэргийн танхимын тэргүүн М.Батсуурь “Алтангадас” одонгоор шагнагдсан явдалд тэдгээрт баяр хүргэж, хүндэтгэл үзүүлсэн цэцгийн баглааны үнэ 159.500 /нэг зуун тавин есөн мянга таван зуу/ төгрөгийг төсвийн зохих зардлаас гаргахыг Санхүү, хангамж үйлчилгээний хэлтсийн дарга Н.Булгамаад зөвшөөрсүгэй.

ДАРГА

Ж.НАРАНПҮРЭВ

